# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 18 өдөр Дугаар А/634 Улаанбаатар хот

Багануур дүүргийн Усан спорт, боулингийн төвийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилчдаас хандивласан нийт 3,280,000.0 (гурван сая хоёр зуун наян мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Багануур дүүргийн Усан спорт, боулингийн төв (Б.Олонтүмэн)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Багануур дүүргийн Усан спорт, боулингийн төв (Б.Олонтүмэн)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/634 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Усан спорт, боулингийн төв

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Үзүүлэлт | Ашиглалтад авсан он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэлд авах | | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Нэгжийн үнэ | Нийт үнэ | |
| 1 | Ус буцалгагч | KLSEN | | 2024 | Сайн | ш | 1 | 800,000.0 | 800,000.0 | Ажилчдын хандив |
| **Машин тоног төхөөрөмжийн дүн** | | | | | Сайн | ш | | | **800,000.0** | |
| 1 | Модог сандал | | | 2024 | Сайн | ш | 6 | 80,000.0 | 480,000.0 | |
| 2 | Буйдан | | | 2024 | Сайн | ш | 5 | 400,000.0 | 2,000,000.0 | |
| **Тавилга, эд хогшлийн дүн** | | | | | | | | | **2,480,000.0** | |
| **Нийт бүртгэх хөрөнгийн дүн** | | | | | | | | | **3,280,000.0** | |